

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-9

1. “Нотлох баримт цуглуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл	4-9
--	-----

Монгол Улсын Их Хурлын “Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 34 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: Б.Жаргалан.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал Хянан шалгагч, шинжээч томилох асуудал, Оюу Толгой төсөл, үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсох гэсэн хэлэлцэх асуудлын дарааллын 1, 2 дахь асуудлуудыг хаалттай явуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, Ө.Шижир нарын тавьсан асуултад Түр хорооны дарга О.Батнайрамдал, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Онончимэг нар хариулж, тайлбар хийв.

О.Батнайрамдал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 12 цаг 00 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Хаалттай хуралдаан 12 цаг 00 минутаас 13 цаг 20 минутад хаалттай горимоор хуралдав.

Нэг. “Нотлох баримт цуглуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Онончимэг, мөн газрын ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал “Нотлох баримт цуглуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

О.Батнайрамдал: “Нотлох баримт цуглуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн саналыг тусган баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 5

Татгалзсан 1

Бүгд 6

83.3 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 36 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР

ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУ ТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН
АШИГЛАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ
ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРООНЫ 2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая Оюу Толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаар Хянан шалгах Түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 9 сарын 01-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Отгоншарын Батнайрамдал, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Пүрэвжавын Ганзориг, Сархадын Зулпхар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Өлзийхүүгийн Шижир. Нийт 1, 2, 3, 4, 5, 6, 7. Энхбатын Болормаа гэсэн 7 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Өнөөдөр Энхбатын Болормаа гишүүн Шинэ Зеландын парламентын дарга бас айлчилж байгаатай холбоотойгоор сая дуудагдаад гарчихлаа.

Тэгэхээр Энхбатын Болормаа гишүүнийг ирцээс гаргахыг хүсье ээ. Болчихлоо. Ингээд нийт 6 гишүүн буюу нийт ирц 54.5 хувьтай ирц бүрдсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

Хянан шалгах Түр хорооны хянан шалгагч болон шинжээчдийг томилох,

Оюу Толгой төсөл үйл ажиллагааны талаарх Эрдэнэс Оюу Толгой ХК-ийн танилцуулга болон бусад гэсэн 3 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё оо. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх Түр хорооны хянан шалгагчийг шинжээчийг томилох нь Түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллахад хянан шалгагч шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай.

Мөн Эрдэнэс Оюу Толгой болон Онтрэ хувьцаат компанийн талаарх түр хорооноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нарийвчилсан мэдээллийг хийх учраас хаалттай хуралдааны горимын саналыг гаргаж байна.

Иймд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллах хянан шалгагч, шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай. Ер нь шинжээчдийн нэрсийг бид нар олон нийтэд гаргахгүй нууцлах ёстой. Ялангуяа шинжээчид сонсгол дээр хүртэл нууцлалтай байх ёстой.

Тийм учраас хаалттай горимоор явуулах саналыг дэвшүүлж байна аа. Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье. Асуулт байна.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Нөгөө эрх зүйн хувьд нэгэнт хэрвээ ингээд бид нарын энэ тогтоол хаалттай горимоор батлагдаад явчихвал цаашдаа бүх зүйл нөгөө нийтэд хаалттай байна л гэсэн үг. Тэгэхээр энэ хаалттай байна гэдэг чинь бид нар хаалттай мэдээлэл байхгүй байгаа биз дээ. Ганцхан тэр шинжээчдийн тогтоолыг батлах үедээ гэдэг тусгай нөхцөлтэйгөөр л хаасан нь зүйтэй юм болов уу. Тэгэхгүйгээр нийтэд нь хаалттай гэдэг горимоор бид нар хурлаа хуралдуулаад шийдвэр гаргачихвал энийг ил болгож чадахгүй болно оо. Бид нар ядаж хэвлэлд юм ярьж чадахаа болино оо.

Тэгэхээр зөвхөн тэр шинжээч томилохтой холбогдсон хүний нэр ус, алдар нэр, албан тушаал, тэрэнтэй холбогдсон асуудлаар хаалттай байна гэдгээр явсан нь зүйтэй байх гэж санал гаргаж байна.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүний саналыг мэдээж хүлээж авалгүй яах вэ. Монгол УИХ-ын тухай хуулийн 21.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг бас хаалттай хэлэлцэж болно. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хуралдаанд оролцсон гишүүдээс олонхын саналаар бид нар хаалттай хэлэлцүүлгийн горимтой байгаа хуультай. Тэгэхээр шинжээч томилох болон бусад тэр асуудлуудаа бид нар хаалттай горимоор яваад Оюу Толгой төслийн мэдээлэл авахыг ил илээр явуулах бүрэн боломжтой байгаа.

Тэгэхээр эхлээд бүгдээрээ хаалттай горимоор явах асуудлаа хэлэлцчихээд Эрдэнэс Оюу Толгойгоос мэдээлэл сонсохоо нээлттэй явуулъя гэсэн горимоор тэгвэл бүгдээрээ санал хураая. Яах вэ Пүрэвдаваа гишүүн шүүмжлээд байна л даа. Бидэнд нэг нь хаалттай нөхцөл байдал яг тэр хүмүүсийн хэлсэнтэй нь бусад нөгөө удирдамж хийх ажлын даалгавар эд нар болно. Тэр нь хаалттай байгаа биз дээ. Бид нар хэрвээ. Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Бид нар чинь нөгөө хууль гэдэг тоног төхөөрөмжөөр шийдвэр гэдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа улсууд шүү дээ. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын хуульд нийцэж байх ёстой байгаа. Манай ажлын хэсэг чинь ер нь бол яг УИХ-ын тогтоолоор 82 гишүүнтэй төлөөлөөд сууж байгаа. Бид хэд арван хэдэн хүн байгаа шүү дээ.

Тэгэхээр тэрний шийдвэр гаргах тийм дотоод энэ ажлын хэсгийн дэг батлагдсан байх ёстой. Өнөөдөр бид хэд энд нууцаар гээд төлөөлөөд 7 хүн ч гэдэг юм уу ингээд ирц хүрлээ гээд явчхаж байна шүү дээ. Бид нарт яг тэр эрх нь олгогдсон яг шийдвэр гараагүй байхгүй юу. Хаалттай байлгана уу үгүй юу. Энэ бүх мэдээллийг хаах уу, нээх үү гэдэг эрхийг.

О.Батнайрамдал: Энэ үгүй шүү дээ. Энэ хуулиараа явж байгаа шүү дээ. Хуулиараа бид нарт эрхтэй.

Д.Пүрэвдаваа: Бишээ биш. Ажлын хэсэг чинь. Бас нэг нийт УИХ-ын тогтоолоор чинь наян хэдэн хүн орсон биз дээ? 89 гишүүн тийм үү? Гарын үсэг зурсан. Төлөөлөөд нөгөө 15 хэд үү, 11 гишүүн. 11 түр хороо зөв үү? Түр хороо ажлын хэсгийн хоорондын харилцааны тэр зохицуулсан дотоод хэм хэмжээ юу байна аа?

Тэр тодорхойгүй байгаа учраас энэ дээр бас шийдвэр гаргах нь. Би бол эрх зүйн талаасаа харж байгаа юм.

Зулпхар гишүүн.

Д.Пүрэвдаваа: Ер нь би бол нөгөө анхны гараа сайн, бариа сайн гэдэг шиг тэгэхгүй дараа нь нөгөө ажлын хэсэгт орсон наян хэдэн хүн эдгээр улсууд дур мэдэн хэм хэмжээ тогтоогоогүй байхад хаах, нээх эрх нь та нарт байхгүй ээ. Ийм асуудал тавигдвал яах вэ? Баярлалаа.

О.Батнайрамдал: Энэ дээр УИХ-ын Тамгын газраас бас тайлбар хуулийн тайлбар өгчихье. Онон даргын микрофон.

Ч.Онончимэг: Нээлттэй явж байгаа, хаагаагүй учраас нээлттэй явж байгаа гэсэн үг.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүний асуултад УИХ-ын Тамгын газрын ажлын хэсгээс Онон дарга хариулъя. Онон даргын микрофон.

Ч.Онончимэг: Их Хурлын тухай хуулийн 15.2-т УИХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган байна. Чуулган нь нэгдсэн хуралдаан Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас шийднэ гээд. УИХ-ын 2025 оны 62 дугаар тогтоолоор нийт 11 гишүүнтэй Хянан шалгах түр хороо байгуулагдсан. Хянан шалгах түр хорооны үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалт, хуралдааны дэг дараалал дээр Монгол УИХ-ын Хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулаад явж байгаа. Хянан шалгах түр хороо маань өөрөө Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг баримтлаад хуралдаанаа хийгээд явах буюу 11 гишүүний олонх ирснээр хуралдааныг эхлүүлэх асуудлыг шийдвэрлэх ийм дэгтэй.

О.Батнайрамдал: Онон даргын микрофоныг.

Ч.Онончимэг: Шижир гишүүний асуултад хариулъя.

Их Хурлын тухай хуулийн 21.3-д хэлэлцэх асуудлынхаа шинж байдлыг харгалзан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гээд, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.3-д УИХ-ын тухай хуулийн 21.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гээд заасан байгаад байгаа. Мөн Хянан шалгагч, шинжээч нарын томилох асуудал маань өөрөө манай Хянан шалгах түр хорооны дотоод асуудал байгаад байгаа учраас гээд. Тэгээд Хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлд бол Түр хороо нь Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхийг эдлэхээс гадна дараах бүрэн эрхийг эдэлнэ гээд нийтдээ 5 бүрэн эрхийг түр хороон дээр нэмж олгосон байгаад байгаа.

Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхээс гадна Байнгын хорооны эрх болон түр хороо нь Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхээс гадна. Аан 21.3 уу? Тийм. Их Хурлын тухай хуулийн 21.3 байхгүй юу. 21 дүгээр зүйл чуулганы хуралдааны нийтлэг журам гээд тэрэн дотроо.

О.Батнайрамдал: Саналаа хураая.

Тэгэхээр Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналын хүрээнд өнөөдрийн хэлэлцэх асуудлын 1, 2 дахь дугаартай асуудлуудыг хаалттай горимоор явуулах саналыг дэвшүүлж байна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

Гишүүдийн 83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

Нээлттэй хуралдаан үргэлжлэв.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараагийн асуудал. Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 түр хорооны хуралдаанаар тусгай шалгалтын сэдвийн хүрээнд хамаарах нотлох баримтыг цуглуулах, гэрчээр дуудах, шинжээч, хянан шалгагчийг томилох асуудлыг хэлэлцэн шийднэ мөн биз дээ? Шийдвэрлэж тогтоол гаргана. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудал руу үндэслээд дэлгэрэнгүй тайлбарлаж 3 удаа санал хураалт тавьж болно гэж заасан. Түр хорооны өнөөдрийн хуралдаанаар Нотлох баримт цуглуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төслийн хавсралтад дурдсан нотлох баримтыг гаргуулах талаар та бүхнээс урьдчилан санал авсан байгаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя аа.

Нэлээн урт юм унших нь байна шүү манайхан.

Нотлох баримт цуглуулах тухай Монгол УИХ-ын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол УИХ-ын 2025 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол УИХ-ын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, өртөг өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх сэдвийн хүрээнд АМГТГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтын 1 дүгээр хавсралтаар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас гаргуулах нотлох баримтлалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, АТГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас гаргуулах, нотлох баримтын жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 5 дугаар хавсралтаар ЗГХЭГ-аас гаргуулах, нотлох баримтын жагсаалтыг 6 дугаар хавсралтаар, Монголбанкнаас гаргуулах, нотлох баримтын жагсаалтыг 7 дугаар хавсралтаар, Монгол УИХ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 8 дугаар хавсралтаар, ТЕГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 9 дүгээр хавсралтаар, Татварын ерөнхий газраас гаргуулах нотлох

баримтын жагсаалтыг 10 дугаар хавсралтаар, УБЕГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 11 дүгээр хавсралтаар, Улсын дээд шүүхээс гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 12 дугаар хавсралтаар, УЕП-оос гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 13 дугаар хавсралтаар, Усны газраас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 14 дүгээр хавсралтаар, Үндэсний аудитын газраас гаргуулах Нотлох баримтын жагсаалтыг 15 дугаар хавсралтаар, ҮАБЗ-өөс гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 16 дугаар хавсралтаар, Сангийн яамнаас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 17 дугаар хавсралтаар, СЗХ-ноос гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 18 дугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалт худалдааны газраас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 19 дүгээр хавсралтаар, ЦЕГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 20 дугаар хавсралтаар, Онтрэ хариуцлагатай ХК-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 21 дүгээр хавсралтаар, Оюу Толгой хариуцлагатай ХК-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 22 дугаар хавсралтаар, Рио Тинто, Монгол ХХК-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 23 дугаар хавсралтаар, Эрдэнэс Монгол хариуцлагатай ХК-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 24 дүгээр хавсралтаар, Эрдэнэс Оюу Толгой хариуцлагатай ХК-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 25 дугаар хавсралтаар, ГЕГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалтыг 26 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёрдугаарт, хавсралтад дурдсан нотлох баримтуудыг холбогдох байгууллага хуулийн этгээд хуульд заасан шаардлагад нийцүүлэн тогтоосон хугацаанд бүрэн гүйцэд гаргаж өгөх үүрэгтэй болохыг дурдсугай.

Гуравдугаарт, хавсралтад дурдсан нотлох баримтуудыг холбогдох байгууллагуудаас хуулийн шаардлага хангуулж гаргуулж олж авах мэдээллийг нууцлан чандлан хадгалах, хянан шалгах, түр хорооны тусгай шалгалтын цаг хугацаанд чанартай гүйцэтгэж дүгнэлт тайланг сонсголд танилцуулах танилцуулгыг хянан шалгагч нарт үүрэг болгосугай.

Дөрөвдүгээрт энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах Түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн Хянан шалгах түр хорооны тогтоолыг та бүхэндээ танилцуулж байна.

Энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Бадамсүрэн гишүүн байна. Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

М.Бадамсүрэн: Нотлох баримт цуглуулах тухай тогтоолын төсөл дээр ТЕГ-аас гаргуулах нотлох баримтын жагсаалт гэдгийг энэ хавсралтыг хуулиар тус байгууллагад харьяалуулсан. Энэ асуудлаар маргаан хэрэг үүсэн шалгагдаж байсан эсэх гэдэг 1 дүгээр заалт байгаа.

Хоёрдугаарт нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Түр хорооны зүгээс анхаарах ийм зүйлүүдийн талаар гэсэн ийм яг хууль тогтоомжид заасан энэ хүрээндээ энэ жагсаалтаа шинэчилж энэ хавсралтаа тэгж шинэчилж явуулах нь зөв байх гэж бодож байна. Тогтоолоо гаргаад тийм ийм саналтай байна. Бадамсүрэн гишүүний саналын засвартайгаар бүгд тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлдэнэ үү гишүүд ээ.

Санал хураалт.

Нийт 6 гишүүн оролцож 83.3 хувьтай тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүдэд баярлалаа. Эргээд хаалттай горим руугаа шилжье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА